

ГЭРЧИД ХУУЛЬ БУСААР НӨЛӨӨЛӨХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЧИГ ХАНДЛАГАД ХАМААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ASPECTS RELATED TO THE TENDENCY OF CORPUS DELICTI THAT INFLUENCES ON WITNESS ILLEGALLY



С.ХАШ-ЭРДЭНЭ

Тахарын ерөнхий газрын Хуяглан хүргэх хэлстийн дарга, тахар,
ХСИС-ийн докторант

KHASH-ERDENE S.

Head of Prisoner Transportation Division Marshal Authority of Mongolia
Ph.D candidate of Graduate school, Law Enforcement University

Товч утга: Энэ илтгэлд гэрчид хууль бусаар нөлөөлөх асуудлыг илрүүлэх, эрсдэлийн түвшинг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлох зарим асуудлыг хөндөнө.

Abstract: The report is the identification of witness intimidation, and will begin its review of factors that increase the risk.

Монгол Улсын Эрүүгийн хууль аливаа гэмт халдлагаас нийгэм, төр, иргэний аюулгүй байдлын баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахдаа цаг үеийнхээ улс төр, үзэл суртал, нөхцөл байдал, нийгмийн шаардлага, эрх зүйн соёл, ухамсар, үнэт зүйлсийг хамгаалж шинэчлэгдэх, нэмэлт өөрчлөлтүүд оруулах үйл явцтай тулгарч байсан онцлогтой.¹ Энэхүү нэмэлт, өөрчлөлтүүд нь хохирлын хэмжээ, гэмт хэргийн үйлдэл, эс үйлдэхүй дэх нөхцөл байдлыг тодорхой болгох, шинэ төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, Монгол Улсын нэгдсэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэхтэй уялдан холбогдож байдаг.

Хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлтийг оруулж эрх зүйн харилцаанд харьцангуй урт хугацаанд тогтвортой үйлчлэх нэгэн үндэслэл нь эрдэмтэн, судлаачдын судалгааны ажил, эрдмийн бүтээлтэй салшгүй холбоотой, нийгмийн хэрэгцээ, шаардлага ч үүнийг тодорхойлж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 256 дугаар зүйлд "...Гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх"..., 256.1 дэх хэсэгт "...Хүч хэрэглэх, эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, шан харамж өгөх зэргээр гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлсэн, шинжээчээр худал дүгнэлт гаргуулсан, орчуулагчаар худал орчуулуулсан, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлсэн" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон.

Харин эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулагдаж буй Монгол Улсын Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 21.5 дугаар зүйлд "Гэрч, шинжээч, орчуулагч,

¹ http://www.moj.gov.mn/images/files/huuliintusul/Criminal_code_2014_04_23.pdf

хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг “Гэрчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх зорилгоор өөрт нь болон ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, шан харамж амласан, өгсөн” гэж тодорхойллоо.²

Гэрчид хууль бусаар нөлөөлөх³ зарим асуудал

Гэрчид хууль бусаар нөлөөлөх асуудалд дүн шинжилгээ хийх нь туслах хэд хэдэн асуудлыг тодорхойлсон. Энэхүү асуудлын нэгээхэн хэсэг нь Цагдаагийн албаны алба хаагч, ажилтнуудын үйл ажиллагаа, арга замаар тодорхойлогдож эцэст нь, гэрчид хууль бусаар нөлөөлөх асуудалд хариу өгөхөд оршино.

Гэрчид хууль бусаар нөлөөлөх нь цаашид үүсэх хор хөнөөлөөс гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалахтай холбоотой асуудлын том багц, нэг хэсэг нь юм. Эрх зүйн орчинд энэхүү асуудлаар тусад нь шинжилгээ, судалгаа хийх шаардлага тулгарч байгаагүй ч хууль зүйн шинэтгэлийн хүрээнд онцолж судлах шаардлага гарч ирснийг тодорхойлсон.

Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн гаж үзэгдэл, айлган сүрдүүлэх, хүн худалдах, худалдагдсан эмэгтэйчүүдийн ашиглах, галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг үйлдэх, гэмт бүлэглэл болон зохион байгуулалттай үйлдэгдэх гэмт хэргийн цаана эмзэг нотолгооны эх сурвалж болсон гэрчийн асуудал, гэрчид хууль бусаар нөлөөлөх үйлдлүүд илэрнэ. Олон улсын түвшинд гэрчид хууль бусаар нөлөөлөх асуудлыг шүүх, прокурорын шатанд онцгой ач холбогдолтой байдлаар тодорхойлж ирсэн ч, энэ нь цагдаагийн байгууллагын зүгээс илүү чухал ач холбогдолтой хэмээн томъёолсон. Энэхүү томъёоллоор цагдаа байгууллагын үйл ажиллагаа хамгийн их хамаарал татаж байгаа асуудал тул асуудалд хариу хэрхэн өгөхийг цаашид анхаарлаа хандуулья.

Гэрчид хууль бусаар нөлөөлөх гэмт хэрэг нь олон төрлийн үүрэг гүйцэтгэж, бусад асуудалтай холбогдон цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаанд байнга тааралдаж байгаа ч гэрчийг айлган сүрдүүлэх хөдөлгөгч хүч нь анхны гэмт хэргийн талаар мэдүүлэг өгсөнөөр тэдний дараа дараагийн хохирлын хариу ирдэг.

Асуудлын ерөнхий тодорхойлолтоор⁴ гэрч, эсвэл гэмт хэргийн хохирогч болдог иргэн цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаар, эсхүл гэмт этгээдийн үйлдлийг нотлоход туслах дургүй байдаг. Энэ дургүйцэл нь гэмт хэрэгтэн буюу түүний хараат хариу арга хэмжээг ойлгох, бодит аюул заналхийлэлд өртөж болзошгүй хэмээх бодлыг агуулж явдаг.

Зарим олон нийтийн зүгээс гэрчлэлт, гэмт хэрэг үйлдсэн этгээд, тэдний гэр бүл, найз нөхдийн хоорондоо нягт хэлхээ холбоотой байдал нь гэрчлэлтийг зогсоох, гэрчид хууль бусаар нөлөөлөх ойлголттой маш чухал нөхцөл байдлаар холбогдож байдаг. Практик туршлагаас үзэхэд, гэрч айлган сүрдүүлэх нь зохион байгуулалттай гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байдаг гэсэн тодорхойлолт байсан боловч сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, гэмт бүлэглэл, хүчирхийлэл болон шинэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах хүчин чармайлт бүтэлгүйтэж ирсэнтэй холбогдож байна.

² <http://www.moj.gov.mn/images/files/huuliintusul/Taniltsuulga%20gemt%20hereg.pdf>

³ Witness Intimidation

⁴ <http://www.popcenter.org/library/awards/goldstein/2011/11-55.pdf>

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5⁵ дугаар зүйлийн "... Нэр томьёоны тодорхойлолт"..."-ийн 5.1.10-д "бусад оролцогч"-оор тодорхойлсон "гэрч" нь цагдаагийн байгууллагад мэдээлэл өгч чадах эсвэл энэ байгууллагын хажуугаар нь өнгөрөх аль алинд хамааруулан ашиглана.

Гэрчүүдийг айлган сүрдүүлэхтэй холбоотой шалтгаан, нөхцөлөөр цагдаагийн алба хаагч нартай "бусад оролцогч"-д хамтран ажиллахаас татгалзсаар ирлээ. Цагдаагийн байгууллагад итгэх итгэл, үйл ажиллагааны дутагдалтай ажиллагаанаас болж "амьд хүний гэрч болохоор, үхсэн хүний дэр болсон дээр" гэсэн хэлц үг олон нийтийн дунд ам дамжин яригдсаар байна.

Гэрч айлган сүрдүүлэх үйлдэл нь олон хэлбэртэй байдаг:

- далд аюул харагддаг эсвэл дохио зангаа,
- хүчирхийлэл буюу тодорхой аюул,
- бодит биеийн хүчирхийлэл,
- эд хөрөнгийн хохирол,
- бусад олон хэлбэртэй.

Энэхүү хэлбэрийг ялангуяа, гэмт хэрэгтэнүүдийг зүгээс гүйцэтгэж болно.

- гэрчийг хэл амаар доромжлох,
- тэмдэглэл, захидал илгээх,
- утсаар дуудлага хийх,
- гэрчийн гэр оронд, ажил төрөл дээгүүр харагдах, тааралдах, уулзах нөхцөл бүрдүүлэх,
- гэрчид эд хөрөнгийн болон бусад төрлийн хохирол учруулах,
- гэрчийн хүүхэд, эхнэр нөхөр, эцэг, эх эсвэл гэр бүлийн бусад гишүүдэд аюул учруулах,
- халдлага эсвэл бүр санаатай алах гэмт хэрэг гэрч болон тэдний гэр бүлийн гишүүдэд чиглэгддэг.

Аюул занал нь бодит бие махбодийн хүчирхийлэлд илүү их нийтлэг байдаг бөгөөд үнэнийг хамгаалахад цагдаа, иргэний хамтын ажиллагааг хэрэгжүүлж тогтоон барих нь үр дүнтэй арга боллоо. Зарим гэрч айлган сүрдүүлэх ганц явдлыг мэдрэх боловч, айлган сүрдүүлэх нь цаг хугацааны явцад улам хэрцгий болж, аюул занал, арга нь улам бүр ихэсч цуврал хэлбэрт шилждэг. Бусад гэрч нь шууд сүрдүүлгийг мэдрч, тэд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллавал болзошгүй аюул заналхийллээс хамгаалагдаж болно гэдэгт итгэж байна.

Гэрчид хууль бусаар нөлөөлөх нь түгээмэл бөгөөд харилцан уялдсан 2 хэлбэртэй.

1. Тохиолдлын айлган сүрдүүлэлтийг цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөх эсвэл тодорхой тохиолдолд гэрчилж өгөх.

2. Олон нийтийн хүрээнд үүссэн айлган сүрдүүлэх ерөнхий мэдрэмж буюу цагдаа, прокурорын хамтын бус ажиллагааны хандлагыг бий болгох үйлдэл багтана.

Гэрч айлган сүрдүүлэх хууль бус үйлдлийн тархалт олон шалтгааны улмаас тооцоолон судлахад хэцүү байдаг.

Учир нь Нэгдүгээрт, гэрчид хууль бусаар нөлөөлсөн хэд хэдэн хүчин зүйлийг хуульчилж, бусад хууль бус үйлдлүүдийг тодорхойлоогүй.

Хоёрдугаарт, Айлган сүрдүүлэлтийг мэдрэхгүйгээр гэрч, хохирогч нь анхны гэмт хэргийн талаарх мэдээллийг бүрэн мэдээллэдэг.

⁵ <http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59>

Гуравдугаарт, хохирлын судалгааг тодорхойлох, хууль хяналтын байгууллагаар явж гэрчүүдтэй ярилцлага хийх боломж дутагдалтай. Гэмт хэргийг шүүхэд шилжүүлэх явцад олон тооны гэрч хавтас хэргээс арчигдаж, мэдээлэл өгөхгүй хөндийрсөөр байгааг судлаж, шинжлэх шаардлагатай.

Эцэст нь хэлэхэд, нийгмийн цар хүрээ, олон нийтийн онцлог шинж чанарын хүрээнд гэрчид хууль бусаар нөлөөлөх үйлдлийн талаар ямар ч эмпирик судалгаа байхгүй байна. Өөрөөр хэлбэл, хууль хяналтын байгууллагын бодит бус судалгаагаар гэрчийг айлган сүрдүүлэх үйлдэл нь түгээмэл бөгөөд өсөн нэмэгдэж байгааг олон нийт тодорхойлон харуулж байна.

Гэрчийг айлган сүрдүүлэх үйлдлийн тархалт нэмэгдсэн нь Монгол Улсад үйлдэгдэн гарсан (2003-2013 оны харьцуулалт⁶) гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн шинж чанар өөрчлөгдөж, энэ нь нийгмийн болон сэтгэл зүйн доорх хүчин зүйлийн тусгалаар илэрч байна.

- Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийн хувь,
- Амьдралд итгэх итгэл алдарсан иргэдийн хувь,
- Төрөл бүрийн гэмт зан, үйлдэл бүхий бүлэглэл үүсэх,
- Галт зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл ашиглах хүсэл, мэдрэмж

нэмэгдэх,

- Ялын бодлогыг тодорхойлж, хариуцлагыг тогтворжуулах бодлого.

Үүнээс гадна, гэрчийг айлган сүрдүүлэх гэмт үйлдэлтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн системд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж, эрүүгийн эрх зүйн бодлого ард иргэдийг хамгаалж чадахгүй байгаа гэсэн ойлголт бий болсоор байна.

Эрх зүйн шинэтгэлийн бодлогод Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдын эрх, үүргийг өргөжүүлэх, баталгаажуулах, хамгаалах үр дүнтэй стратеги бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Энэхүү бодлоготой уялдан хэрэгжүүлэх Олон улсын туршлага, арга хэмжээний саналыг тодорхойлвол:⁷

Үр дүнтэй хариу арга хэмжээ стратегийн ерөнхий анхаарах зүйлс				
№	Хариу арга хэмжээ	Хэрхэн ажиллах вэ?	Гол ажил	Анхаарах асуудал
	Олон агентлаг түншлэлийг бүрдүүлэх	Гэрч гэмт хэргийг мэдээлэх, шүүн таслах үйл явцын туршид хамгаалагдсан гэдгийг батлах	Чиг үүргийн байгууллагуудын хоорондын гэрээ, эрх үүрэг, хүлээх хариуцлага	Албан ёсны гэрээнд цаг хугацаа шаардлагатай; агентлагийн ажилтнууд гэрч, нууцлалыг хангах ёстой; хамтын үүрэг хариуцлагыг тодорхойлох

⁶ 2003-2013 оны гэмт хэргийн мэдээ, Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, судалгааны төв,.

⁷ Bauer, R., C. Hasler, M. Myrent, R. Przybylski, G. Ramker and J. Travis (1997). An Evaluation of the Illinois State Police Gang Crime Witness Protection Program. "Иллиной мужийн Цагдаагийн байгууллагын гэрчийг хамгаалах хөтөлбөрийн үнэлгээ.

	Хязгаарлах үүрэг	Хууль эрх зүйн сорилт, гэрчийн нэрийн өмнөөс авсан бүх арга хэмжээг баримтжуулна	Айлган сүрдүүлэх тайланг нухацтай авч байх; үнэмлэхүй хамгаалах баталгаатай байх; гэрч хамгаалалтын арга хэмжээний талаар шийдвэр гаргахад оролцож байх	Цагдаа нар хамгийн сайн хүчин чармайлт байсан хэдий ч, гэрчүүд цаашдын хамтын ажиллагаанд нөлөөлж хохирох
	Цагдаа, иргэдийн хоорондох харилцааг бэхжүүлэх	Эрүүгийн хэрэгт хамтын ажиллагааг санал болгох; аюулгүй байдлыг мэдрүүлэх, цагдаагийн үйл ажиллагааг чанаржуулах	Төв, орон нутгийн онцлогт тохирсон холболт, хамтын ажиллагааг нэвтрүүлэх	Олон нийттэй харилцах хүчин чармайлт цаг хугацаа, тэвчээр шаардах
	Хамгийн сайн стратеги сонгох нь	Гэрч шүүхэд хэрэгтэй байгаа нөхцөл байдлыг хязгаарладаг	Эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ, иргэний учирсан гэм хорыг арилгах	Хүчирхийллийн гэмт хэргийн шийтгэл хөнгөн байж болно
	Гэмт хэргийн хавтаст материалтай танилцах үед гэрч танигдах эрсдэл тулгардагийг багасгах	Иргэд, цагдаа нарын хоорондох харилцаа холбоо, аюулгүй боломжуудыг олгодог	Гэрч гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээлэл хийх аргын сонголт олгох	Цагдаа нараас гэрчийн мэдээлэл алдагдаж болно
	Гэрчийг хэн болохыг хамгаалах	Гэрчийн нэр, хаягийг сурах нь гэмт хэрэгтнээс сэргийлнэ	Цагдаагийн радио дээр цацах мэдээллийн төрлийг хязгаарлах;	Гэрчийн бүтэн нэрийг ашиглахгүй
	Дохиолол болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төхөөрөмжийг ашиглах нь	Гэрч, хохирогчийн гэр бүл рүү зөвшөөрөлгүй нэвтрэх илүү хэцүү болгодог бөгөөд гэрч, аюулгүй байдлыг илүү мэдрэмж өгдөг;	Гэрч зөв төхөөрөмжүүдийг ашиглахын тулд бэлтгэгдсэн байна; гэрч байнга төхөөрөмжүүдийг ашиглах	Аюулгүй байдлын төхөөрөмжүүд нь зардал ихтэй байж болно; зохисгүй хэрэглээ нь хуурамч дохио хэмжээг ихэсгэж болно
	Гэрч болон гэмт хэрэгтний хооронд холбоо магадлалыг бууруулах	Айлган сүрдүүлэх боломжийг багасгадаг	Гэрч зайлсхийх тактик хэрэглэн ажиллана	Гэрч тактиктай байна

	Гэрчийг дэмжих нь	Хамтын ажиллагаа нь хялбар болгох, илүү үнэн зөв мэдээлэл өгөх гэрчийг бэлтгэх хохирсон сэтгэл хөдлөлийн үр нөлөөг авч үзсэн	Хэрэгцээг төрүүлж шийдвэрлэх үйлчилгээг өргөн хүрээтэй хэрэглэх эрхтэй байх; Тэдний үйл хэргийг бүрэн бүтэн байдлыг умартаж болохгүй тул зохих сургалтанд хамруулж байна	Тэд ачаалал ихтэй болго, гэрчийг дэмжснээр дангаараа хариуцлага хүлээхгүй болно
	Шүүхийн танхимд гэрч, хариуцагчийг байлгах нь	Айлган сүрдүүлэх боломжийг бууруулна;	Гэрч нь өмгөөлөгч буюу сайн дурын хамт байгаа	Олон гэрчид нэг өдөр үйлчилгээ үзүүлэх шаардлагатай бол хэрэгжүүлэхэд хэцүү байж болно
	гэрчийг шилжүүлэн суурьшуулах	Аюултай газар нутаг гэрчүүдийг устгана	Гэрч, хохирогчийн сэтгэл санаа, санхүүгийн, дотоодын хэрэгцээг шийдвэрлэх боломжтой	Гэрчүүдийн хөтөлбөрийн дүрмийг дуулгавартай дагах хүсэлтэй байж болохгүй; гэрч, сэтгэл санааны хүнд цохилт болно
	Айлган сүрдүүлэлтийг нэмэгдүүлэх нь ял шийтгэлтэй уялдах	Гэмт хэрэгтний үйлдлийг хязгаарлах боомилж	Айлган сүрдүүлэх нь хүнд гэмт хэрэг түвшинд тодорхойлогдоно; ял дараалан үйлчилж байх ёстой	Айлган сүрдүүлэлтийг нотлох хэцүү байдаг
	Хууль бус нөлөөллийг татах	гэмт хэрэгтнийг Нэмэгдэж эрсдэл,	айлган сүрдүүлэлтийг хүчингүй болгох нь өмнө тэнсэн суллах буюу тэнсэн харгалзан үзэх	Нотлох айлган сүрдүүлэх тохиолдол нь хэцүү байж болох юм